

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2017 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын нэр:	2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал		
Огноо:	2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 11:00-13:00	Уулзалтын газар:	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хурлын заал
Хурлын дарга:	Ч.Пүрэвсүрэн, МЦХ ХК-ийн Стратеги төлөвлөлтийн газрын дарга		
Тооллогын комисс:	Ш.Нурдаулет, Нягтлан бодох бүртгэлийн албаны ахлах ня-бо /Тооллогын комиссын дарга Н.Ачитсайхан, Бизнес төлөвлөлтийн албаны дарга Т.Баярцогт, Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Д.Болдбаатар, Удирдлага, хүний нөөцийн газрын дарга /Зохион байгуулах комиссын дарга/ Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Удирдлага, хүний нөөцийн газрын хуулийн ахлах мэргэжилтэн		
Оролцсон хувьцаа эзэмшигчид	Ц.Баяр-Эрдэнэ	ТӨБЗГ, Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч 14,143,604 ширхэг (54.67%)	Нийт хувьцааны тоо 24,705,493.0 ширхэг (95.49760%)
	Жү Хонг Сик	КТ корпорацийн итгэмжлэгдсэн төлөөлөгч 10,348,111 ширхэг (40%)	
	Н.Мөнгөнтуяа	Хувьцааны тоо 280 ширхэг (0.00108%)	
	Д.Төмөрбаатар	Хувьцааны тоо 20 ширхэг (0.00008%)	
	Х.Сурмиа	Хувьцааны тоо 350 ширхэг (0.00135%)	
	Ч.Баттөмөр	Хувьцааны тоо 13 ширхэг (0.00005%)	
	Б.Зууннасан	Хувьцааны тоо 110 ширхэг (0.00043%)	
	Н.Удмаа	Хувьцааны тоо 70 ширхэг (0.00027%)	
	BDSEC	Хувьцааны тоо 1,980 ширхэг (0.00765%)	
	М.Отгонбаяр	Хувьцааны тоо 200 ширхэг (0.00077%)	
	Firebird GM2 S.A.R.L	Хувьцааны тоо 199,970 ширхэг (0.77297%)	
	Fury Mogul	Хувьцааны тоо 9,610 ширхэг (0.03715%)	
	А.Чулуун	Хувьцааны тоо 255 ширхэг (0.00099%)	
	Г.Батнасан	Хувьцааны тоо 15 ширхэг (0.00006%)	
	Г.Баасанжав	Хувьцааны тоо 5 ширхэг (0.00002%)	
	М.Алтан-Очир	Хувьцааны тоо 210 ширхэг (0.00081%)	
	Д.Сумъяа	Хувьцааны тоо 350 ширхэг(0.00135%)	
	Ж.Баатар	Хувьцааны тоо 40 ширхэг (0.00015%)	
	Г.Алтан-Оч	Хувьцааны тоо 200 ширхэг (0.00077%)	
	Централ Эйшиа	Хувьцааны тоо 100 ширхэг (0.00039%)	
Ирц:	95.50%		

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2017 оны зардлын төсвийг батлах
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэр, тогтоолыг танилцуулах

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.12-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор ХЭХ хүчин төгөлдөр болно.” гэж заасны дагуу 24,705,493 саналын эрхтэй 20 хувьцаа эзэмшигч хуралд ирж 95.50 хувийн ирцтэй байна.

Ч.Пүрэвсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурал хуралдуулах ТУЗ-ийн шийдвэр, хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцууллаа.

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт, 2017 оны зорилтын талаар танилцуулав.

Ц.Мөнх-Эрдэнэ, ТУЗ-ийн хараат бус гишүүн: Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийн танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, СТГ-ын дарга: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд сонгогдох нэр дэвшигчид, ТУЗ-ийн 2017 оны зардлын төсвийн төслийг тус тус танилцуулав.

Ц.Баяр-Эрдэнэ, МУ-ын Төрийн өмчийн төлөөлөл: Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх тайлбар, ТУЗ-ын тогтоолыг танилцуулав.

Санал, асуулт хариулт

Т.Цогтбаяр, Централ эйшиа инвестмент ХХК: 1. Гүйцэтгэх захирлаас асуулт: Хөрөнгө оруулалтыг 6,5 тэр бум төгрөг, өнгөрсөн жил төлөвлөсөн хөрөнгө оруулалтаас 2 тэрбум төгрөгөөс бусад нь хийгдээгүй гэж байна. Энэ ажлуудаа тусгасан уу, энэ хөрөнгө оруулалтын ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх гээд байна вэ? Баталгаат эх үүсвэрээр үү эвсэл өөр мөнгө зээл, бусад ямар байдлаар санхүүжүүлэх вэ? 2. ТУЗ-ийн дарга, гишүүдээс асуулт: Энэ компанийн хэтийн хөгжил, төрөөс 55 хувийн хувьчилна гэж байгаатай уялдуулаад хувьцаа нэмж гаргах, хувьцааны үнэ цэнд өөрчлөлт оруулах, үнэлгээг өөрчлөх асуудал хэтийн төлөвт орж байгаа юм уу, ороогүй байгаа юм уу? 3. Сүүлийн жилүүдэд ногдол ашиг хуваарилахгүйгээр яваад байна ш дээ. Энэ олон жил хуримтлагдсан ашгийг хасах хүртэл нь ногдол ашиг хуваарилахгүй яваад байга гэж байгаа юм уу? Би ямар санал хэлэх вэ гэхээр 2015 оны жилийн эцсээр 28 т.б төгрөг, 2016 оны жилийн эцсээр 27.7 т.б төгрөг хуримтлагдсан ашигт байна. Хуримтлагдсан ашигт байгаа юмыг бид ногдол ашиг байдлаар хуваарилах бүрэн боломжтой, өнөөдөр та нар зөвхөн мөнгө байдлаар хуваарилахаар ойлгож байна. Өнөөдөр мөнгө хэрэгтэй байж болно. Өнөөдөр Компанийн тухай хуульд ногдол ашгийг үнэт цаас хэлбэрээр бусад компанийн үнэт цаас хэлбэрээр, эд хөрөнгийн эрх хэлбэрээр хуваарилж болно гэж байдаг. Ингэвэл бидний хувьцаа жижиглэгдэж 25 сая хувьцаатай биш 100 сая хувьцаатай болох боломж бололцоо байна. Хувьцаагаар ногдол ашгаа хуваарилах маягаар энийг үнэлгээн дотроо оруулаад ирвэл бид нарын тоо ширхэг ч нэмэгдэнэ. Өнөөдөр компанийн хувьцаа 550 төгрөгтэй яваа юм байна. 550 биш 1000 дээш явах боломж бололцоо байна. Бид нар бол жижиг хувьцаа эзэмшигч нар хувьцааны ханшийн зөрүүнээс ашиг олох гэж байгаа. Ногдол ашиг авч ашиг хүртэх гэж байгаа шүү дээ. Үүнд нийцүүлж мөнгөөр ногдол ашиг хуваарилах тухай ярихаас илүүтэй мөнгөн бус хэлбэрээр ногдол ашиг хуваарилах бодлого цаашид барих юм уу, энэ 28 тэрбумаа хувьцаагаар ногдол ашиг болгоод өгвөл компанийн үнэлгээ үнэ цэнэ нэмэгдэх гээд байна. Энийг барих юм уу, энэгүйгээр байнга хасах болгоод бууруулаад яваад байх зарчим барих юм уу.

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Энэ жил батлагдсан 6,5 тэр бумыг өөрийн хөрөнгөөр хийнэ. Ямар нэг зээл, хөрөнгө оруулалт авахгүй. Ноднин жилийн хөрөнгө оруулалт шиг болгохгүйн төлөө хичээж ажиллах болно. Зөв хөрөнгө оруулалт хийгээгүй. Зөв хөрөнгө оруулалт хийж байж та бүхний хувьцаа үр өгөөжтэй болно. Энэ дөрвөн жилд компанийг тэсрэлттэй болгох, чиг хандлагыг гаргах хүндрэлтэй ч суурийг нь зөв тавих нь чухал байна. Суурийг нь зөв тавьсан учраас энэ компани 96 жил амжилттай явж ирсэн. Та бүхэн зөв зүйтэй, мэргэжлийн баг ирсэн гэж ойлгох хэрэгтэй.

Ц.Баяр-Эрдэнэ, МУ-ын Төрийн өмчийн төлөөлөл: 2017 оны зорилтот түвшинг төлөвлөхдөө хувьчлагдах, хувьчлагдахгүйг ямар нэг байдлаар зохицуулах шаардсан зүйл байхгүй. Ер нь 2017 онд хувьчлалын талаар яриа гарахгүй гэж ойлгож байгаа. Төсвийн тодотгол хийсэн хуулинд хувьчлалаас олох орлогыг үндсэнд нь тэглээд оруулсан. Тийм учраас энэ компанийн үнэлэмжийг сайжруулах, үнэ цэнэтэй болгох, ашигт ажиллагааг нь сайжруулах зорилго бий болж байгаа.

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Компанийн удирдлагын зарчим ажилчдын 36 сарын цалинг мөнгөн хөрөнгөөр барьж байдаг.

Т.Цогтбаяр, Централ эйшиа инвестмент ХХК: Хуримтлагдсан ашгаа хувьцаа болгоод өгөө чээ тэгвэл бидний үнэ цэнэ өсөх гээд байна.

Т.Эх-Оюун, МЦХ ХК, СХОГ-ын дарга: Энэ хуримтлагдсан ашиг бол жил бүр ногдол ашиг хувьцаа эзэмшигчдээ хуваагаад тэрнээс үлдсэн зүйлийг ярьж байгаа.

Ц.Баяр-Эрдэнэ, МУ-ын Төрийн өмчийн төлөөлөл: Хувьцаа эзэмшигчдийн сонирхол бол мэдээж ногдол ашиг хуваарилах, ашиг хүртэх, бид ч гэсэн тэгж хүсэж байна. Гэхдээ энэ компанийн өнөөгийн байдал үүрээд явдаг нийгмийн хариуцлагыг нь харахаар алдагдалтай гарч байгаа. Ямар нэг байдлаар ашиг харж суугаа. Төр 54 хувь эзэмшиж байгаагийн хувьд ногдол ашиг авдаг байх ёстой. Таны хэлж байгаа зөв л дөө, өөрчлөх, сайжруулах ёстой гэдэг зарчмын санал зөв. Хуримтлалаа авахдаа хууль, дүрэм журмын хүрээнд зохицуулагдана. Компанийн тухай хуулийг барьж явж байгаа тохиолдолд таны хэлж байгаа зүйл өөрөө эргэлзээтэй. Нягтлан бодох бүртгэл, бүх зүйл ашигтай, ашиггүй гээд гараад ирж байгаа учраас таны саналыг дэмжиж байна. Гэхдээ хэрэгжүүлэхэд түвэгтэй зүйл байхгүй юу.

Ж.Баатар, хувьцаа эзэмшигч: Алтан-Очир захирлын илтгэлийг сонслоо. Ер нь МЦХ ХК сүүлийн үед их тааруу ажиллаж байгаа ажиглагддаг. Бусад адил компаниуд илүү өрсөлдөх чадвартай гараад ирж байна. Уг нь МЦХ ХК суурь сайтай эцэг маягын компани, энэ талаасаа өөрсдийн давуу талыг ашиглаад тарифын уян хатан бодлого баримтлах нь маш зөв шийдэл байна. Техник технологийн хувьд бусад компаниуд илүү, интернэтийн хувьд МЦХ компанийг голно. Төр 54 хувийг эзэмшиж байж анхаарах хэрэгтэй. Алдагдалтай хэцүү нөхцөлд ажиллаж байгаа ч сайн ажиллаж байгаа гэж үзэж байгаа. Төрөөс тодорхой анхаарал тавьж ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Энхтунгалаг, хувьцаа эзэмшигч: МЦХ ХК гэдэг бол өөрөө МУ-ын МХХ-ны салбарын хамгийн үндсэн сүлжээтэй байгууллага. Энэ компани ийм ашиггүй болтлоо, ажиллагаа нь ийм байдалтай доголдуулахад хэн буруутай вэ? гэвэл би төр буруутай гэж хэлнэ. Яагаад гэвэл ерөөсөө МУ-ын Харилцаа холбооны салбар тоон технологи руу шилжиж байх үеэс эхлээд МЦХ ХК-ны үндсэн сүлжээг төрийн өмч нэрээр дур дураараа хувьчласан нэртэйгээр бүх үйл ажиллагааг саармагжуулсаар ирсэн. Төрийн өмчийн хороо нэртэй байхдаа ямар нэг мэргэжлийн бус, салбар мэдэхгүй, салбар удирдаж чадахгүй тийм боловсон хүчин аваачиж тавьсан бодлогын чинь үр уршиг өнөөдөр гарч байгаа юм. Энэ тал дээр ТӨБЗГ ямар байр суурь илэрхийлж байна? Өнөөдөр жижиг хувьцаа эзэмшигчдийн саналыг авахгүй явж болно. Гэхдээ МУ-ын өөрийнх нь үндэсний аюулгүй байдалд хамааралтай МХХ-ны системд төр цаашид зөв зүйтэй ажиллуулах тал дээр ямар бодлого баримталж, компанийг алдагдлаас гаргах вэ?

Ц.Баяр-Эрдэнэ, МУ-ын Төрийн өмчийн төлөөлөл: Таны хэлж байгаатай санал нэг байна. Төрийн оновчгүй бодлого, зохицуулалт, хөрөнгө оруулалтын дутмаг байдал, зах зээлийн хөгжил, техник технологийн шинэчлэл энэ компанийг энэ байдалд хүргэж байгаа. Гэхдээ бид нилээн олон талаас нь ярьсан. Бидний хувьд ТӨБЗГ-ын баримталж буй зарчим бол нэгдүгээрт энэ компанийг мэргэжлийн, улс төрөөс хамаарал багатай тийм баг удирдах ёстой гэсэн зарчим барьсан. Бид ийм багийг бүрдүүлсэн гэж ойлгож байгаа. Одоо энэ багтай хариуцлага тооцож шахаж, шаардаж ажиллана гэсэн зорилт тавьж ажиллаж байгаа. Цаг хугацааны явцад үр дүн гарах байх. Төрөөс цаашид аль салбараа дэмжих, аль салбараа бариад явах, хэдэн хувьд нь хяналтын багцад хөрөнгө оруулалт хийж явах гэдэг төрийн өмчийн бодлогын баримт бичигтэй болох асуудал яригдаж байгаа. Үнэхээр авч явж чадахгүй, төр менежмент хийж чадахгүй бол хувьчлах хэрэгтэй, чадах нь авч явах хэрэгтэй. Ийм л хариулт өгөх байна.

Г.Алтан-Оч, хувьцаа эзэмшигч: Олон жилийн дараа мэргэжлийн баг ирж байгаад баяр хүргэе. Олон жил хурал дээр хэлсэн өрсөлдөгчийн чадвар хурц болсон мэдээллийн зах зээл дээр ийм бодлого баримтлаад явахгүй гээд хэлээд байхад дандаа мэргэжлийн бус хүмүүс ирдэг. Шинэ технологи оруулах талаар юм хий гээд үг авдаггүй. Төрийн өмчийн хороо сүүлийн жилүүдэд үнэхээр бодлого баримталж чадаагүй, ТУЗ-ийн гишүүдэд мэргэжлийн бус хүмүүс авчраад тавьдаг. ТУЗ-ийн ердийн гишүүд нь болдог гэхэд хараат бус гишүүдэд уг нь мэргэжлийн хүн тавих нь зүйтэй байх. Шинэ багт цаашдын ажилд амжилт хүсье.

Бичгээр ирсэн санал:

Энхтунгалаг, хувьцаа эзэмшигч: 1. Дараагийн ХЭХ-д (2018 онд) санал асуулга хэлэх хугацааг хүн болгонд 3-5 минут болгож өгөх; 2. Жижиг хувьцаа эзэмшигч нараас санал авахын тулд дор хаяж 10 хүний саналыг авч байх; 3. Цаашид мэргэжлийн хүмүүсээр компанийг удирдуулахын тулд жил бүр харилцаа холбооны мэргэжлийн хүнээр компанийг удирдуулах.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 99.9941 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9941 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
 - Нийт хөрөнгийг **39,000,359,074** (гучин есөн тэрбум гурван зуун тавин есөн мянга далан дөрөв) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 18,344,099,700 (арван найман тэрбум гурван зуун дөчин дөрвөн сая ерэн есөн мянга долоон зуу) төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг **20,656,259,374** (хорин тэрбум зургаан зуун тавин зургаан сая хоёр зуун тавин есөн мянга гурван зуун далан дөрөв) төгрөгөөр
 - Өр төлбөрийн нийт дүнг **8,635,063,743** (найман тэрбум зургаан зуун гучин таван сая жаран гурван мянга долоон зуун дөчин гурав) төгрөгөөр
 - Эзэмшигчийн өмчийг **30,365,295,330** (гучин тэрбум гурван зуун жаран таван сая хоёр зуун ерэн таван мянга гурван зуун гуч) төгрөгөөр тус тус баталсугай.
3. Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын хорооны дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9941 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын хорооны дүгнэлтийг тус тус батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Г.Эрдэнэбулган, О.Хуягцогт, Ц.Баяр-Эрдэнэ, Жу Хён Мин, хараат бус гишүүдээр Кан Ён Мин, Ж.Тамир, Л.Болормаа нарыг сонгож батлав.
 - Компанийн үр ашигтай үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг 99.9941 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг Хавсралт ёсоор батлав.
 - Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

Тэмдэглэл хөтөлсөн:

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Танилцсан:

Ч.Пүрэвсүрэн, 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга



2017 оны 4 дүгээр сарын 28
Улаанбаатар хот.